



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

9021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 4/180

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 17 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Дээрх хугацаанд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, сүм хийдийн болон бусад хурал, цуглаан, үзэсгэлэн худалдаа, караоке, аялал зугаалга, хурим, найр, саун, бассейн, спорт заал, амралтын газар, жуулчны бааз, фитнесс төвүүдийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, бусад аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай зохион байгуулж удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Уранбямба), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дээрх хугацаанд аймгийн хэмжээнд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд бүрэн хамрагдсанаас хойш 14 хоног болсон, сүүлийн 4 сарын хугацаанд халдвараар өвчилж эдгэрсэн иргэдээс бусад иргэдийн PCR шинжилгээний хариуг шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

481210495

5. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулсугай.

6. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдэд 18 градусаас доош спиртийн агууламжтай согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн зөвшөөрсүгэй.

7. Дээрх хугацаанд улсын чанартай автозам дагуух цайны газруудын үйл ажиллагааг хориглосугай.

8. Аймгийн нутаг дэвсгэрт барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилчдыг нэвтрүүлэх түр журмыг баталж, мөрдүүлэн хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

9. Коронавируст “Ковид-19”-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, тэмцэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

